БАТЛАВ.

"КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА"-НЫ ДАРГА ........../Ч.ЗОЛБАЯР/

# "ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЧИГЛЭСЭН КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ" ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

| | | |
|---|---|---|
| 1 | Ажлын зорилго | Кибер аюулгүй байдлын үйлчилгээг авах |
| 3 | Захиалагч байгууллага | Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба |
| 4 | Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр | Урсгал: 398,000,000 |
| 5 | Ажил гүйцэтгэх хугацаа | Үйлчилгээний гэрээ байгуулснаас хойш 6 сар |
| 6 | Гүйцэтгэх ажил | 1. Монгол Улсын интернэт сүлжээний орчин дахь Кибер аюул занал, нөхцөл байдлын талаар 7 хоног бүр тайлан мэдээ бэлтгэж, танилцуулах<br>2. Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн кибер халдлага, зөрчлийн талаар улирал тутам тайлан мэдээ бэлтгэж, танилцуулах<br>3. Монгол Улс болон бүс нутагт руу чиглэсэн цахим орчин дахь хортой код, холбоос, контентод шинжилгээ хийж, сар бүр тайлан гаргах<br>4. Кибер халдлага зөрчилтэй холбоотой мэдээ мэдээллийг тухай бүр шаардлагатай талуудын хооронд солилцож, будилаан зохицуулах, тухай бүр мэдээллийг ирүүлэх<br>5. Халдлага зөрчилд хариу үзүүлэх чиглэлээр олон улсын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай харилцан, мэдээлэл солилцох, тухай бүр мэдээллийг ирүүлэх<br>6. Кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах шийдэл боловсруулах, танилцуулах<br>7. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй хувийн хэвшлийн байгууллагуудын дунд цахим халдлагын сургуулилт зохион байгуулах 1 удаа<br>8. Шаардлагатай тохиолдолд захиалагч талын хүсэлтээр дээр дурдсанаас гадна, кибер аюулгүй байдлыг хангах үйлчилгээг хийж гүйцэтгэх.<br>9. Кибер халдлага, зөрчил гарсан тохиолдолд зөрчлийг зохицуулах, удирдахад дэмжлэг үзүүлэх |

| | | |
|---|---|---|
| | | 10. Иргэн, байгууллагуудад зориулсан аюулгүй байдлын стандарт, заавар, зөвлөмж боловсруулан, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.<br>11. Кибер аюулгүй байдлын ажлын албаны болон кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвүүдийн хэрэглэж буй систем, платформд кибер аюулгүй байдлын шалгалт, сорилт хийх.<br>12. Монгол Улсын интернэт сүлжээний орчин дахь Кибер аюул занал, нөхцөл байдлын мэдээлэл цуглуулж болох эх үүсвэрүүдийг тодорхойлж кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвүүдийг хэрэглэх заавар боловсруулж сургалт орох. |
| 7 | Үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлага | 1. Кибер аюулгүй байдлын чиглэлээр сүүлийн 8 жил болон түүнээс дээш тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байх;<br>2. Нийтийг хамарсан кибер аюулгүй байдлын арга хэмжээг жил бүр зохион байгуулсан байх (сүүлийн 5 жил)<br>3. Кибер аюулгүй байдлын салбарын мэргэжилтнүүдийг хамарсан кибер аюулгүй байдлын арга хэмжээг жил бүр зохион байгуулсан байх (сүүлийн 5 жил)<br>4. Кибер аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын ашгийн бус 2-с дээш байгууллагад гишүүнчлэлтэй байх; Түүн дотроо кибер халдлага зөрчилд хариу үзүүлэх үйл ажиллагаа бүхий байгууллагын гишүүнчлэлтэй бол давуу тал болно.<br>5. Үйлчилгээ үзүүлэгч тал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:<br>- Кибер аюулгүй байдлын чиглэлээр их дээд сургууль төгсөж мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан туршлагатай дөрөв болон түүнээс дээш гишүүд<br>- Кибер аюулгүй байдлын чиглэлээр судалгаа шинжилгээний бүтээл олон улсад нийтлүүлж байсан туршлагатай хоёр болон түүнээс дээш гишүүд<br>- Гишүүд Олон улсын мэргэжлийн холбоо, стандартын байгууллага, эсхүл түүнтэй дүйцэхүйц байгууллагаас олгосон хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх<br>- Халдлага зөрчилд хариу үзүүлэх олон улсын байгууллагын мэргэжлийн сургалт, семинарт хамрагдаж байсан бол давуу тал болно |
| 8 | | |